



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 709

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11 нэрийн нийт 291,896,946.08 (хоёр зуун ерэн нэгэн сая найман зуун ерэн зургаан мянга есөн зуун дөчин зургаан төгрөг найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарын бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн  
70.8 дугаар тогтоолын хавсралт

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА САЛБАР, НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон	Тоо хэмжээ (ш)	Нэгжийн үнэ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Салбар, нэгжийн нэр
							(аймаг)
1	УАЗ 39094 15-20 APX, 330360C0489231	2012/2012	1	40,948,772.52	40,948,772.52	500,000.00	Архангай аймгийн Мал эмнэлгийн газар
2	УАЗ 390992,13-07 APX,0473610	2012/2012	1	20,000,000.00	20,000,000.00	500,000.00	Архангай аймгийн Мал эмнэлгийн газар
3	УАЗ 390945 19-80 БУА, ХТТ390945C467720	2012/2012	1	40,948,772.52	40,948,772.52	1,000,000.00	Булган аймгийн Мал эмнэлгийн газар
4	Фотон Форланд, 70-32 ДАА, LVA4JW635J026967	2005/2005	1	25,313,000.00	25,313,000.00	500,000.00	Дархан-Уул аймгийн Мал эмнэлгийн газар
5	Ачааны автомашин, Dongfeng, CLW5050 XLC3, 71-29 ДОР, LGDTK81G29A159787	2009/2010	1	46,298,394.00	46,298,394.00	2,000,000.00	Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар
6	УАЗ 220695-355, 39-49 ДУА, 70406093	2006/2006	1	17,575,000.00	17,575,000.00	500,000.00	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар
7	УАЗ31512, 39-00 ДУА, 70566144	2006/2006	1	13,040,279.74	13,040,279.74	500,000.00	Дундговь аймгийн Мал эмнэлгийн газар
8	УАЗ 31514, 66-58 ОРХ, 315100B0589830	2011/2011	1	17,272,727.30	17,272,727.30	500,000.00	Орхон аймгийн Мал эмнэлгийн газар
9	Ариутгалын авто машин (Foton HLQ5043), 36-81 СУА, LVBV3JBB4AN030448	2010/2010	1	30,000,000.00	30,000,000.00	2,000,000.00	Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газар
10	Ланд крузер-80, 40-80 УВА, FZJ800116888	1995/2010	1	26,000,000.00	26,000,000.00	1,000,000.00	Увс аймгийн Мал эмнэлгийн газар
11	УАЗ 469, 00-33 УВА, 90527759	2009/2009	1	14,500,000.00	14,500,000.00	500,000.00	Увс аймгийн Мал эмнэлгийн газар

<p style="text-align: center;"><b>Нийт дүн</b></p>	<p style="text-align: center;">291,896,946.08</p>	<p style="text-align: center;">9,500,000.00</p>	<p style="text-align: center;">-</p>
	<p>(Хоёр зуун ерэн нэгэн сая найман зуун ерэн зургаан мянга есөн зуун дөчин зургаан төгрөг найман мөнгө)</p>	<p>(есөн сая таван зуун мянган)</p>	<p style="text-align: center;">-</p>